

8
127

**УЛААНБААТАР ХОТЫН
НАМЫН ХОРОО
А. Д. Х. ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ТОГТООЛ**

196 6- 6-2

Дугаар 383/185

Улаанбаатар хот

**ТРАКТОР КОМБАЙНЫ ЖОЛООЧ НАРЫГ БЭЛТГЭХ
КУРС БАЙГУУЛАХ ТУХАЙ**

МАХН-ын Төв хорооны улс төрийн товчоо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1964 оны 21/29-р тогтоолыг биелүүлэх арга хэмжээний тухай авч хэлэлцээд Улаанбаатар хотын Намын хороо, АДХ Гүйцэтгэх Захиргаанаас ТОГТООХ НЬ:

1. Трактор комбайны жолооч нарыг бэлтгэх 3 дахь удаагийн курсийг 200 хүнтэйгээр хөдөө а/а-н дээд сургуулийн дэргэд 1966 оны 6-р сарын 10 наас эхлэн 45 хоногийн хугацаатайгаар байгуулж курсийн захиралаар хөдөө а/а-н дээд сургуулийн механикийн декан н.Жүрмэд, хичээлийн эрхлэгчээр багш н.Пүрэвжав нарыг томилсугай.

2. Хотын албан байгууллагуудаас курст суралцах хүний хувиарыг хавсаралтаар баталсугай.


3. Курст 4-оос дээш ангийн боловсролтой цаашид тогтвор сууршилтай ажиллаж машина механизмийн жолоочийн мэрэгжил эзэмшиж чадах залуучуудыг хувиарт газруудаас тогтоосон хугацаанд нь гаргаж өхийг хотын эвлэлийн хороо, н.Гунгаажав, районы намын хороо, АДХ Гүйцэтгэх Захиргааны дарга нарт даалгасугай.


4. Курсийн зардал төсвийг 6-р сарын 10-ны дотор хянаж батлаж өхийг санхүүгийн хэлтэс /н.Цэрэнпил/-д даалгасугай.

219
MB

- 2 -

5. Курейг зохион байгуулж эхлүүлэх ба тариа хураалтаар сангийн а/а-нуудад хувиарлан практик хийлгэхийг хотын ХЦХ-ны товчоо / н.Сэдбазар/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН НАМЫН
ХОРООНЫ I-Р НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА  АЛТАНГЭРЭЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ ГҮЙЦЭТГЭЛ
ЗАХИРГААНЫ ДАРГА  ЦЭДЭВ

НИЙДСЭН.....

I7% цо...Б....